

Өөрийгөө сорiorой

1. $M = -187 \times 5$; $N = 429 \div (-13)$; $O = (-992) \div 31$; $P = 125 \times 8$ бол $M + N + O + P$ утгыг ол.
а. 130 б. 0 в. 2000 г. -870
2. Дэс дараалсан таван натурал тооны нийлбэр тэгш тоо байж чадах уу?
а. Байж болно б. Болохгүй в. Тэгш, сондгой аль ч байж болно.
3. Дараах тооцооллыг зөв хийсэн эсэхийг тайлбарлаарай.
 $(-48) \div (-6) \times 2 = (-48) \div (-12) = 4$
4. $\sqrt{225} - (-20) + (-6)^2 - 8^2$ утгыг ол. а. 135 б. -25 в. 7 г. -7
5. Тэгш өнцөгт параллелепипедийн уртыг 2 дахин, өргөнийг 4 дахин ихэсгэв. Параллелепипедийн өндрийг хэрхэн өөрчилбөл эзлэхүүн хэвээр үлдэх вэ?
а. 2 дахин ихэсгэнэ б. 2 дахин багасгана в. 8 дахин ихэсгэнэ. г. 8 дахин багасгана.
6. B дүрс 2 удаа бүтэн эргэхэд A дүрс 5 удаа бүтэн эргэдэг бол A дүрс 35 удаа бүтэн эргэхэд B дүрс хэдэн удаа бүтэн эргэх вэ?
7. 15-аас их, 42-оос бага 5-д хуваагддаг тоонуудын олонлогийг C , 30-аас их 60-аас хэтрэхгүй 4-д хуваагддаг тоонуудын олонлогийг D гэж тэмдэглэв. $C \cup D, C \cap D$ олонлогийн бүх элементийг олоорой.
8. Хайрцагт 4 улаан, 8 хар, 5 ногоон өнгийн харандаа байв. Хайрцагаас хэсэг харандааг харалгүйгээр авахад тэдгээрийн дотор:
а. Өнгө бүрээс ядаж нэг харандаа
б. Нэг өнгийн 6 харандаа байлгахын тулд хамгийн цөөндөө хэдэн харандааг авах хэрэгтэй вэ?
9. Цэгийн оронд байх үгтэй нь холбоорой.
а. Зөвхөн хоёр хуваагчтай натурал тоог ... гэнэ.
б. Хэд хэдэн тоог нэгэн зэрэг хуваадаг тоог тэдгээрийн ... гэнэ.
в. Хэд хэдэн тооны ерөнхий хуваагчдын хамгийн ихийг тэдгээрийн ... гэнэ.
г. ХИЕХ нь 1 байх хоёр тоог тоонууд гэнэ.
д. Хэд хэдэн тоонд зэрэг хуваагддаг тоог тэдгээрийн ... гэнэ.
е. Өгөгдсөн хэдэн тооны ...-ыг тэдгээрийн хамгийн бага ерөнхий хуваагдагч гэнэ.
10. 3 см өндөртэй улаан хайрцаг, 5 см өндөртэй цэнхэр хайрцгуудыг давхарлан өрж тавьсан байв. 2 хайрцгийн хамгийн эхлээд тэнцэх өндрийг ол.
11. Тахиа, туулайн нийт тоо 31 байв. Тэдний нийт хөлийн тоо 90 бол тахиа, туулай тус бүр хэд байсан бэ?
12. Солонгод 3.2л, Дөлгөөнд 4250мл, Хуланд 2565мл сүү байв. Тэдэнд нийт хэдэн литр сүү байсан бэ?
13. $\square + 3 < 5$ нөхцөлийг хангах тоон олонлогийг сонгоорой.
а. $\{-3; 1; 9; -5\}$ б. $\{-1; -13; -9; 1\}$ в. $\{-2; -11; 2; -7\}$
14. Дараалсан таван натурал тооны үржвэр 10-д хуваагдана гэсэн өгүүлбэр ямагт үнэн байх уу?

